



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/69

Мөрөн сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурал зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, 48 дугаар зүйлийн 48.3, 52 дугаар зүйлийн 52.1.10, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.2, 61.7 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, "Могойн гол" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.6, "Могойн гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Могойн гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 11.00 цагт, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх "Иргэний танхим"-д хуралдуулахаар зарласугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр баталсугай.

а/ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдлийг 01 дүгээр хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдлийн хяналтын хуудсыг 02 дугаар хавсралтаар, саналын хуудасны загварыг 03 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Хурал зарлах өдрийг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр, дахин мэдээлэх өдрийг 09 дүгээр сарын 21-ний өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 09 дүгээр сарын 25-ны өдрөөр, эцнээ санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүлээн авах эцсийн өдрийг 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөр тус тус тасалбар болгосугай.

5. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Должинсорогдог (Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга)
Гишүүн: Б.Батхүү (Компанийн гүйцэтгэх захирлын ажлыг хавсран гүйцэтгэгч)
Н.Төмөрхуяг (Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн)
Т.Урангэрэл (Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга)

6. Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Одончимэг (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ахлах мэргэжилтэн)

Захирамж 2023

6710001223

Гишүүн: Б.Угтах-Эрдэнэ ("Хөвсгөл Ус суваг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга)

7. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон холбогдох хууль тогтоомжийг хариуцлагатай мөрдөж, хурал зохион байгуулахыг комиссын дарга (Б.Должинсорогдог), тооллогын комиссын дарга (Б.Одончимэг) нарт даалгасугай.

ДАРГА



Г. МӨНГӨНХУЯГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын даргын 2023 оны 09 дугаар
сарын 01 өдрийн А/89 дугаар
захирамжийн 01 дүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	"Могойн гол" ХК
Хаяг, утас	Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, 7-р баг, утас:99898922, 99058438
Хурал хуралдах өдөр, цаг	2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 11.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, аймгийн ЗДТГ-ын "А" байр, III давхар, "Иргэний танхим"-д
Хурлын төрөл:	Ээлжит бус
Хурал зарлагч	Орон нутгийн өмчийн 51 хувийг эзэмшигч- Хөвсгөл аймгийн ИТХ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2023.09.01
Олон нийтэд зарлах огноо	2023.09.06
Бүртгэх өдөр	2023.09.25
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2023.09.11
Хүргүүлсэн огноо	2023.09.11
Хурлын даргын нэр	Б.Должинсорогдог
Тооллогын комиссийн дарга, гишүүдийн нэр	Комиссын дарга: Б.Одончимэг Гишүүд: Б.Угтах-Эрдэнэ
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	<ul style="list-style-type: none">- Хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын тэмдэглэл- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээллэх зарын загвар- Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа
Баримт, бичгийн хуудсын тоо хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОММИССЫН ДАРГА  /Б.Должинсорогдог/

2023 оны 09 дугаар сарын 01-ний өдөр

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын даргын 2023 оны 09 дугаар
сарын 01 өдрийн 1/69 дугаар
захирамжийн 02 дугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	ЗҮЙЛ	ТАЙЛБАР
1	Компанийн нэр	"Могойн гол" ХК
2	Хаяг, байршил	Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, 7-р баг
3	Хурал зарласан огноо	2023.09.01
4	Хурал зарлагчийн мэдээлэл	Аймгийн ИТХ
5	Хороонд ирүүлсэн огноо	2023.09.04
6	Олон нийтэд зарлах огноо	2023.09.06
7	Эхний зарласнаас хойш 15 хоногт дахин зарласан эсэх	2023.09.21
8	Бүртгэлийн өдөр	2023.09.25 /тийм/
9	Хэлэлцэх асуудал	1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
10	Саналын хуудасны загвар	Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийндугаар захирамжийн 03 дугаар хавсралтаар
11	Саналын хуудас хүлээн авах өдөр	2023.10.06
12	Хурлын даргын нэр	Б.Должинсорогдог
	Хурлын тооллогын комиссын гишүүдийн нэр	Комиссын дарга: Б.Одончимэг Гишүүд: Б.Угтах-Эрдэнэ
13	Хурал хуралдах огноо	2023.10.13
14	Хурал хуралдуулах газар, байршил	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, АЗДТГ-ын "А" байр III давхар, "Иргэний танхим"-д
	Хурал хуралдуулах огноо, цаг	2023.10.13, 11:00
15	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн нэр	
	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн гарын үсэг	
	Хурлын мэдэгдэл хянасан огноо	



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын ... оны ... дугаар сарын ... өдрийн ... дугаар захирамжийн 03 дугаар хавсралт

“Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчдийн, нэр: Овог, Нэр
Хувьцаа эзэмшигчдийн дансны дугаар
Санал өгөх хувьцааны тоо
Бүртгэсэн/Үнэт цаасны компанийн нэр/.....

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцааны төрөл
Брокерийн овог нэр

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Удирдлагын ордон “А байр”, 3-р давхар, “Иргэний танхим”

Д/д	Санал авах асуудлууд	Хэлэлцэж буй асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Тайлбар
1	1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг
2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Тооллогын комиссын дарга /Б.Одончимэг/
Гишүүн /Б. Угтах-Эрдэнэ/